



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 5/40

Улаанбаатар хот

Тэтгэвэр тогтоолгох, тэтгэмж,
ээлжийн амралтын олговор олгох тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 82.1.3, 83.5 дугаар зүйл, МУБИС-ийн Захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хамтын гэрээний 4.2 дугаар заалт, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр тушаалын хавсралт “Ээлжийн амралт олгох, Ээлжийн амралтын цалин тооцох журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Багш ажилчдын байрны үйлчлэгч Санжхүүгийн Машбат нь өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлтээ гаргасан тул 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс үүрэгт ажлаас нь чөлөөлж, хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгосугай.
2. С.Машбатад тэтгэвэрт гарахтай нь холбогдуулан 3 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 2,733,411 (Хоёр сая долоон зуун гучин гурван мянга дөрвөн зуун арван нэгэн) төгрөгийн тэтгэмж олгосугай.
3. С.Машбатын тэтгэмжийн мөнгийг Захиргаа аж ахуйн данснаас 911,137 (Есөн зуун арван нэгэн мянга нэг зуун гучин долоон) төгрөгийг, МУБИС-ийн Хөгжлийн данснаас 1,822,274 (Нэг сая найман зуун хорин хоёр мянга хоёр зуун далан дөрвөн) төгрөгийг, ээлжийн амралтын олговрыг ажлын 7 хоногоор тус тус тооцож гаргахыг Санхүүгийн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч (М.Уранжаргал), Захиргаа аж ахуйн ахлах нягтлан бодогч (Д.Саранчимэг) нарт зөвшөөрсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод ажлын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Болорцэцэг)-д даалгасугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ О.АЛТАНГОО

